



СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

118 /118/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2021.08.23

ҮЙЛ ЯВДАЛ

"АРАВТ", "ЦЭРГИЙН РАЛЛИ" УРАЛДААНУУД ӨНӨӨДӨР ЭХЭЛЖ БАЙНА



Олон улсын "Аравт" морин цэргийн болон "Цэргийн ралли" уралдааны нээлтийн ажиллагаа өчигдөр боллоо. "Олон улсын цэргийн наадам"-ын хүрээнд зохион байгуулагдаж байгаа энэхүү уралдааны нээлтийн ёслолд ОХУ-ын Зэвсэгт хүчний Хуурай цэргийн командлалын Жанжин штабын төлөөлөгч, хошууч генерал Портных С.В оролцлоо.

Мөн тус арга хэмжээний үер Монгол Улсын багийн ахлагч, ЗХЖШ-ын АУГ-ын дарга, бригадын генерал С.Дашзэвэг баяр хүргэж тамирчдадаа амжилт хүссэн юм. Тэрээр хэлсэн үгэндээ "Дэлхий дахинд тархсан цар тахлыг үл

харгалзан "Аравт" морин цэрэг, "Цэргийн ралли" уралдааныхаа жанжин тугийг бөхийлгөлгүйгээр Тува Улсын газар нутагт мандуулж байгаад бид бүхэн туйлын баяртай байна. Хүн төрөлхтний мянга мянган жилийн түүхэнд морь гэдэг амьтан бол дархлагдсан үнэнч нөхөр бөгөөд дэлхий 2 дугаар дайны үед морин цэрэг нь байлдааны талбарт олон төрлийн үүрэг гүйцэтгэж байсан аугаа түүхтэй юм" хэмээн цохон тэмдэглэлээ.

Нээлтийн ажиллагааны үер "Аравт" морин цэргийн уралдааны гарааны сугалааг сугалсан бөгөөд "Аравт"-ын

салхийг Казахстан Улсын баг 2 дахь удаагаа хагалахаар боллоо. Тодруулбал, "Аравт" олон улсын морин цэргийн анхдугаар уралдаан 2019 онд Монгол Улсад зохион байгуулагдахад нэгдүгээр сугалааг сугалж салхийг хагалж байсан билээ. Мөн энэ удаагийн уралдаанд ч бас ийнхүү хамгийн эхэнд гараанаас гарах боллоо.

Уралдаан энэ сарын 23-нд буюу өнөөдөр эхлэх юм. "Аравт"-д Монгол, ОХУ, Казахстан, Узбекистан Улсын Зэвсэгт хүчний баг тамирчид оролцоно. Уралдаанд оролцох баг тамирчид 8 дугаар сарын 14-22-ны өдрүүдэд уралдааны өмнөх бэлтгэл

сургалтыг 9 цэгт өдөр бүр 2 цагаар гүйцэтгэсэн юм.

Сугалаагаар нэгд Казахстан, хоёрт Узбекистан, гуравт Монгол, дөрөвт ОХУ гараанаас гарна. Ингэснээр алсын зайн маршид 8 дугаар сарын 23-ны өдөр Казахстан, Узбекистан, 8 дугаар сарын 24-ний өдөр Монгол, ОХУ-ын баг тамирчид 110 км замыг таван удаагийн даалгавар гүйцэтгэж барианд орох ёстой юм.

Алсын зайн марш нь хоёр өдөр, нэг шөнө үргэлжилнэ. Харин "Цэргийн ралли" тэмцээнд оролцож буй Монгол Улсын Зэвсэгт хүчний баг өнөөдөр өглөө 07.00 цагт гараанаас гараад байгаа юм.

БРИГАДЫН ГЕНЕРАЛ Н.НАРАН-ОЧИР, ДЭД ХУРАНДАА Х.САНЧИРДОРЖ НАР ОЛОН УЛСЫН ШҮҮГЧИЙН ЭРХ АВЛАА



"Арми игры-2021" тэмцээний шүүгчийн эрх олгох 10 цагийн семинарт бригадын генерал Н.Наран-Очир, танкийн биатлон тэмцээний шүүгчийн эрх олгох 4 цагийн семинарт дэд хурандаа Х.Санчирдорж нар хамрагдаж "Арми игры", "Танкийн биатлон" тэмцээнүүдийг шүүх эрхийн сертификат, үнэмлэх,

шүүгчийн 3 дугаар зэргийн энгэрийн тэмдгийг гардан авлаа.

Манай багийн нэгдүгээр экипаж нээлтийн өдөр буюу өнөөдөр Венесуэл, Сири, Вьетнам улсуудын багтай уралдах бол 2, 3 дугаар экипажууд энэ сарын 26, 29-ний өдрүүдэд уралдана.

Ганцаарчилсан уралдааны төгсгөлд экипажуудын нийлбэр дүнгээр байр эзлүүлж, 1-8 байр эзэлсэн багуудыг хагас шигшээ уралдаанд шалгаруулах юм.

Мөн "Арми игры 2021" тэмцээнд танкийн биатлон, морин марафон, цэргийн ралли гэсэн 3 төрөлд Зэвсэгт хүчний баг тамирчид оролцож

байна. Арми игры тэмцээний хүрээнд явагдаж бүх тэмцээний мэдээлэл, дүн парк патриот дээр ирж нэгтгэгдэж байгаа бөгөөд ямар нэг асуудал гарвал хэлэлцэн шийдвэрлэдэг аж. Энд олон улсын шүүгчээр бригадын генерал Н.Наран-очир ажиллана. Тодруулбал тэмцээн тус тусдаа шүүгчтэй юм.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
12	7

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
32	23

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2.848.0	2.851.0
EUR	3.335.0	3.350.0
CNY	439.0	440.0
RUB	37.50	39.10
JPY	25.55	26.37
KRW	2.35	2.48

ЗУРХАЙ

2021.08.23 БААСАН ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 16/

НАМРЫН ТЭРГҮҮН УЛААН БИЧ САРЫН ДОЛООН УЛААН МЭНГЭТЭЙ ХАРАГЧИН ТУУЛАЙ ӨДӨР

Үс засуулбал:

Өвчин ирнэ

Наран ургах, шингэх:

05.58-19.52

Барилдлага:

Идэр

Шүтэн барилдлага:

Хурьцахуй

Суудал:

Огторгуй

Тухайн өдөр хонь, гахай жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Эл өдөр эе, эвээ ололцох, хамтын хөдөлмөр эхлэх, гэрээ хэлцэл байгуулах, найр хурим хийх, бэр гуйх, инж өвөх, авах, үнэт эрдэнийн зүйл авах, гарагийг тахиx, мал аж ахуйн үйл, удирдлагын суудалд суух, огторгуйн үүдийг боох, их хүмүүнтэй уулзахад сайн. Газар хагалах, ус булгийн эх малтах, улаа гаргах, хиншүү хярвас гаргах, балгадын суурь тавих, нохой худалдан авахад муу. Өдрийн сайн цаг нь хулгана, бар, туулай, морь, хонь, тахиа болой. Хол газар яваар одогсод зүүн хойш мөрөө гаргавал зохистой. Халуун эгэх улирал (6 цаг 38 мин)-д эхэлнэ. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН 194.679 +1780	ЭДГЭРСЭН 178.944 +1934	НАС БАРСАН 898 +2
-----------------------------------	---------------------------	----------------------

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН 4436 +80	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ 155 +9	ЭДГЭРСЭН 4194 +31
-----------------------------	-------------------------------	----------------------

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол Нийт: 212,555,068
Эдгэрсэн Нийт: 190,157,239
Нас барсан Нийт: 4,443,904



ЦАХИМ ШУУДАНД

ХОШУУЧ ГЕНЕРАЛ Р.СҮХБАТ ТАМИРЧДАД АМЖИЛТ ХҮСЛЭЭ



Монгол Улсаас ОХУ-д суугаа цэргийн аттеше, хошууч генерал Р.Сүхбат танкийн биатлон тэмцээнд оролцох баг тамирчдын байрлалд ирж тамирчдын тэмцээний бэлтгэл, байр, ахуй хангалтын байдалтай танилцлаа.

Тэрээр энэ үеэр тамирчдадаа хандан тэмцээндээ биеэ дайчлан бэлтгэл сургуулилтаа сайтар базааж, сандахгүй тайван байж сурсан, дадлагажсан бүхнээ бүрэн гаргаж ажилттай оролцоорой гэв. Мөн ОХУ-д суугаа Онц бөгөөд Бүрэн

эрхт элчин сайд Д.Даваа бие бүрэлдэхүүнтэй утсаар холбогдож Ардын хувьсгалын болон Зэвсэгт хүчний 100 жилийн ой тохиож байгаа энэ тэгш ойн жил амжилттай оролцож улс орон, Зэвсэгт хүчнийхээ нэрийг өндөрт өргөхийг хүсэн ерөөлөө.

10 КИЛОМЕТРИЙН ЯВГАН МАРШ ҮЙЛДЭВ



Зэвсэгт хүчний 013 дугаар анги

Ангийн офицерууд, даргалах албан тушаалын ахлагч нартай явуулах заах арга зүйн цугларалтыг энэ сарын 18, 19-ний өдрүүдэд лекц, дадлагаар явуулав. Цугларалтын хүрээнд Богд хан уулын Баруун ширээтийн чиглэлд 10 километрийн явган марш үйлдэн, багаар ажиллах дадлага, чадвар, байр зүйн баримжаалал илтгэж, спортын тэмцээн уралдааныг зохион байгууллаа.

Ахмад Ц.ЦЭВЭГДОРЖ

ЦАГ ҮЕ

ДУУ ЦАХИЛГААНТАЙ ААДАР БОРОО ОРНО



Ихэнх нутгаар үлэрхэг. Төвийн аймгуудын ихэнх нутаг, говь болон зүүн аймгуудын нутгийн зарим газраар бороо, дуу цахилгаантай аадар бороо орно. Хангай, Хөвсгөлийн уулархаг нутгаар нойтон цас орно. Салхи говийн аймгуудын нутгаар баруун өмнөөс баруун хойш эргэж, бусад нутгаар баруун хойноос секундэд 6-11 метр, говь, тал, хээрийн нутгаар секундэд 15-17 метр хүрч ширүүснэ. Говь-Алтай, Хангай, Хөвсгөлийн уулархаг нутаг, Хүрэнбэлчир орчим, Завхан голын эх, Идэр, Тэс, Орхон, Туул, Тэрэлж голын хөндийгөөр 7-12, Алтайн өвөр говь болон говийн бүс

нутгийн зүүн өмнөд, Дорнод-Дарьгангын тал нутгаар 19-24 бусад нутгаар 12-17 хэм дулаан байна. **УЛААНБААТАР ХОТ ОРЧМООР:** Үүлэрхэг. Бороо орно. Салхи баруун хойноос секундэд 6-11, зарим үед секундэд 14-16 метр хүрч ширүүснэ. 12-14 хэм дулаан байна. **БАГАНУУР ОРЧМООР:** Үүлэрхэг. Бороо орно. Салхи баруун хойноос секундэд 6-11, зарим үед секундэд 14-16 метр хүрч ширүүснэ. 13-15 хэм дулаан байна. **ТЭРЭЛЖ ОРЧМООР:** Үүлэрхэг. Бороо орно. Салхи баруун хойноос секундэд 6-11, зарим үед секундэд

14-16 метр хүрч ширүүснэ. 10-12 хэм дулаан байна. Өглөө 05 цагт Улаанбаатарт: 8 хэм дулаан, харьцангуй чийг 88 хувь, агаарын даралт 862 гектопаскаль байлаа. Даралт өдөртөө тогтвортой байна. Өнөөдөр Дундговийн зүүн, Дорноговийн хойд хэсгээр ахиухан хэмжээний бороо орно. Малчид, иргэд, тариаланчид, хадланчдын анхааралд: Өнөөдөр нутгийн зүүн хагаст бороо, дуу цахилгаантай аадар бороо орж, салхитай байхыг анхааруулж байна. **Эх сурвалж: ЦУОШГ**

ТҮВШИН ТОГТООХ ҮЗЛЭГТ АМЖИЛТТАЙ ХАМРАГДЛАА

Зэвсэгт хүчний 336 дугаар анги

Батлан хамгаалахын сайдын 2021 оны А/107 дугаар тушаалаар батлагдсан "Цэргийн жинхэнэ албаны офицер, ахлагчийн түвшин тогтоох үзлэг явуулах журам"-ын дагуу ЗХЖШ-ын даргын тушаалаар томилогдсон комиссын бүрэлдэхүүн энэ сарын 19-20-ны өдрүүдэд Зэвсэгт хүчний 336 дугаар ангид ажиллаж, түвшин тогтоох үзлэгийг зохион байгуулав.

Офицер, ахлагчийн түвшин тогтоох үзлэгт ангийн бие бүрэлдэхүүн төдийгүй Дорноговь аймгийн Цэргийн штабын бие бүрэлдэхүүн хамрагдаж, хүн нэг бүрийн ажлын гүйцэтгэл, үр дүн, албаны хандлагаа дүгнүүлж, мэргэжлийн ур чадвар, багаар ажиллах чадвараа хамт олноороо үнэлүүлэн, сэтгэл зүйн бэлтгэлжилт, эрүүл мэндийн байдлаар цэргийн жинхэнэ албанд тавигдах шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа эсэхээ тогтоолгож, цаашдын анхаарах шаардлагатай чиглэлээ тодорхойлуулав.

Мөн энэ үеэр ангийн бие бүрэлдэхүүн түвшин тогтоох үзлэгийн бэлтгэлийг сайтар хангаж, хүн нэг бүрийн бүрдүүлэх баримт бичгийг загварын дагуу үнэн зөв боловсруулж, түүнд нь хүний нөөцийн албан тушаалтнууд хяналт тавьж, жигдрэлтийг хангасан нь комиссын бүрэлдэхүүн үзлэгийг богино хугацаанд үнэн зөв, бодитой үнэлэн, үр дүнтэй зохион байгуулахад дөхөм байсан юм.

Бие бүрэлдэхүүний бие бялдрын бэлтгэлжилтийг дээшлүүлэх зорилгоор "Түвшин тогтоох шалгалтад бэлтгэх төлөвлөгөө"-г боловсруулж, түүний дагуу өдөр бүр насны ангиллаар шалгалтын удирдамжид заагдсан нормативыг гүйцэтгэв.

Түүнчлэн бие бүрэлдэхүүний жигдрэлтийг ханган "TG Sport" хувцас хэрэглэлийн үйлдвэртэй гэрээ байгуулсны үндсэн дээр ангийн лого бүхий биеийн тамирын цамц, өмд, шорт, фудволкоор жигдрүүлсэн. Үзлэгийн төгсгөлд комиссын нарийн бичгийн дарга, ЗХЖШ-ын Сургалтын бодлого зохицуулалтын хэлтсийн дарга, хурандаа Ш.Гантөмөр үзлэгийн талаар дүгнэн хэлэхдээ "Цэргийн жинхэнэ албаны офицер, ахлагчийн түвшин тогтоох үзлэгээр та бүхний ажлын гүйцэтгэл, албаны хандлага, үр дүн, сахилга хариуцлага, ёс зүй,



сэтгэл зүйн бэлтгэлжилт, эрүүл мэндийг үнэлж дүгнэх, цэргийн алба хаагч бүр өөрийн түвшнээ тодорхойлж, цаашид ямар зүйл дээр анхаарч ажиллах ёстой вэ гэдгийг ойлгуулаад зогсохгүй манлайлагч офицер, ахлагч нарыг бэлтгэх, нийгэм байр сууриа олсон, манлайлагч иргэдийг бий болгох зорилготой. Зэвсэгт

хүчний 336 дугаар ангийн хувьд үзлэгийн бэлтгэлийг маш сайн хангаж, цэргийн алба хаагчийн зан байдлын тодорхойлолтыг алба тасгийн дарга нар бодитой дүгнэсэн, хувь хүний бичиг баримтыг сайн бэлтгэсэн, удирдлага зохион байгуулалт сайн, дэг журамтай байсан" гэв.

Дэслэгч Ч.БОДЫГЭРЭЛ

ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙГ ИРЭХ АМРАЛТЫН ӨДРҮҮДЭД УЛСЫН ДУГААРЫН ТЭГШ, СОНДГОЙГООР ЗОРЧУУЛНА

Хичээлийн шинэ жил эхэлж буйтай холбогдуулан нийслэлийн замын хөдөлгөөний ачаалал эрс нэмэгддэг тул ирэх амралтын өдрүүдэд тээврийн хэрэгслийг улсын дугаарын тэгш, сондгойгоор зорчуулна.

Тухайлбал, наймдугаар сарын 28-ны бямба гарагт автомашины улсын дугаарын сүүлчийн орон нь тэгш, 29-ний ням гарагт сондгой



тоогоор төгссөн тээврийн хэрэгслийг 8.00-20.00 цагийн хооронд замын хөдөлгөөнд оролцуулна.

Дугаарын хязгаарлалт нь Саппорогийн уулзвараас Офицеруудын ордон, 32-ын тойргоос 120-ын уулзвар хүртэл үйлчлэх аж